

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН СТАНДАРТ БЭЛТГЭХ ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Б.Сайнжаргал, Т.Жааваа

Монголд энгийн тоо бүртгэлээс ангид мэдээллийн баялаг уламжлал, хэмжүүрийн систем байгаагүй, 1920 оноос үндэсний мөнгөн тэмдэгт, хэмжүүрийн систем, 30-аад онд давхар бичилтийн нягтлан бодох бүртгэл, 40 оноос төсвийн бүртгэл нэвтэрсэн. 1960 онд журнал маягт хэрэглэж, 70-аад оноос мэдээллийг автоматжуулах эхлэл тавьж, 80 онд хэмнэлт, чекийн данс, норматив бүртгэл зэрэг шуурхай хяналт нэвтрүүлэхийг оролдсон ч олигтой үр дүнд хүрээгүй, 90 оноос бүртгэлийн уламжлалт систем, тоталитор загварыг халж мэдээллийн даяарчлалд нэгдэх болсон.

Өмнөх бүртгэл дэлхийн жишиг, хөгжлийн түүхэн хандлагыг тусгаагүй, мөнгөн үнэлгээ, орлого хэмжилт, өртөг, үр дүнгийн тайлагналын хувьд нийтийн тогтсон жишгээс ихээхэн зөрүүтэй явж ирсний дээр хүнд суртал, командын тогтолцоо, төлөвлөгөөт хөгжлийн загвар, хатуу үнэ, онц эрх, монополь бүтцэд зохицсон учир зах зээлийн харилцааг тусгаагүй, түүнийг хөгжүүлэхэд саад болж, эрс зөрчилдөх болсон. Тэгээд ч бүртгэлийн загвар, сууриудын тунхаглал, үзэл баримтлал, онолын сурвалжид нийцүүлэн тохируулсан, аккруэл суурьт бүртгэлийн хэрэглээг эдүгээ Зүүн Европ, Төв, Зүүн Өмнөт Азид дэлгэрсэн бүртгэлийн саармаг систем, тоталитор загварын эсрэг сэргүүлэн тавьж, зөв голидролд оруулах нь монгол дахь бүртгэлийн шинэчлэлийн нэн тулгамдсан асуудал юм.

Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг хүлээн зөвшөөрч үндэсний хэмжээнд ашиглах хандлага дэлхийн улс гүрнүүдийн дотор ялангуяа сүүлийн 10 жилд ихэд өссөн. Зүүн Европ, Төв, Зүүн Өмнөт Ази, Африкийн хөгжиж буй, шилжилтийн эдийн засагтай улс гүрнүүдийн хувьд дараах 6 бүлэгт ангилж болно.

Нэг. Олон улсын бүртгэлийн стандартыг үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрч, шууд хэрэглэсэн: Кипр, Кувейт, Латви, Пакистан, Тринидад, Тобаго, Хорват.

Хоёр. Олон улсын бүртгэлийн стандартыг хүлээн зөвшөөрөхийн хамт хараахан тусгаагдаагүй асуудлуудыг үндэсний стандартаар нэмж баяжуулсан: Малайз, Папуа-Шинэ Гвиней.

Гурав. Олон улсын бүртгэлийн стандартыг зөвшөөрөхдөө үндэсний онцлогыг нэмж тодруулсан: Албани, Бангладеш, Барбадос, Замби, Зимбабве, Кени, Колумб, Польш, Судан, Тайланд, Урагвай, Ямаик.

Дөрөв. Олон улсын бүртгэлийн стандартад нэмэлт тайлбар, тодотгол хийж, үндэсний хэмжээнд зөвшөөрч тунхагласан орон: Хятад, Иран, Словени, Тунис, Филиппин.

Тав. Үндэсний стандарт нь олон улсын бүртгэлийн стандартад суурилсан авч, зарим стандартыг үндэсний хүрээнд нарийвчлан авч үзсэн: Бразил, Энэтхэг, Ирланд, Литва, Мавритани, Мексик, Намиби, Нидерланд, Норвег, Португал, Сингапур, Словак, Турк, Франц, Чехословак, Швейцар, Өмнөт Африк.

Зургаа. Үндэсний стандарт нь олон улсын бүртгэлийн стандартад суурилсан ч стандарт бүрийг олон улсын бүртгэлийн стандарттай харьцуулж тодотгосон: Австрали, Гонконг, Дани, Итали, Шинэ Зеланд, Швед, Югослав. Монгол олон улсын бүртгэлийн стандарт хүлээн зөвшөөрч, дэлхийн мэдээллийн даяарчлалд нэгдэн орохдоо үндэсний онцлог, данс, гүйлгээ, журналын бичилтүүдийн нэмэлт бүрэн тайлбар, тодотгол бүхий үндсэн (венчмарк), боломжит (альтернатив) аргын сонголт багатай хувилбарыг авч хэрэглэх нь зүйтэй гэсэн үзэл баримтлалыг бид дэмжсэн¹. Бизнес орчны нягтлан бодох бүртгэлийн үндэсний стандарт бэлтгэх зохиогчдын үзэл баримтлал, олон улсын бүртгэлийн стандартын жишилтүүд (Хүснэгт 1) чухамдаа үүнийг гэрчилнэ.

Хүснэгт 1

Сэдэв: Бизнес орчны нягтлан бодох бүртгэлийн стандарт
Тоо хэмжээ: 32 стандарт ба тайлбар, хавсралт, аргачлал

Код	Стандарт Нэр	Стандартын гол бүрдэл ба агуулга	ОУБС-ээс зөрөх нь:	
			нэмэлт	хасалт
НББ ҮС-0	Санхүүгийн бүртгэлийн тунхаглал (SIC-6)	- Зорилго, үйлчлэх хүрээ, хэрэглэгч - Зорилт, зарчим, чанарын үзүүлэлт - Тодорхойлолт, хүлээн зөвш. хэмжилт - Капиталын үзэл баримтлал	НББОУС-ын үндсэн баримт бичиг ба АНУ-ийн СБ УТ: №1-10 ашиглах	
НББ ҮС-1	Санхүүгийн тайлангийн толилуулга (SIC-8, SIC-18)	- Үйлчлэх хүрээ, зорилго, хариуцлага - Анхааруулга, бодлого ба зарчим - Тодорхойлолт, тайлагнах хугацаа - Баланс: эргэлт хөрөнгө, өр төлбөр - Орлого, өмчийн өөрчлөлт - Тодруулга, Хавсралт: <i>СТ маягт</i>	- "Санхүү тайланг бэлтгэх" ОУБС удиртгалаас энд ашиглах - Санхүү тайлан маягтын монгол загварыг хавсаргах	"Санхүүгийн тайлангийн аргачлал", "Санхүү тайлангийн тодруулга" үндэсний зааврыг энд ашиглах
НББ ҮС-2	Бараа материал нөөц (SIC-1)	- Зорилго үйлчлэх хүрээ, нэр томъёо - Өртөг: бэлтгэл, хувиргалт, бусад - Хэмжилт: <i>Гүйцэтгэл</i> , стандарт, ЖҮ - Зарлагын арга: Т/Т, венч, альт, бусад - ЦБӨ: шууд, шууд бус арга - Тодруулга, <i>тайлбар хавсралт</i> (данс бичилт, зөвлөмж аргачлал)	- Гүйцэтгэл өртгөөр пункт нэмэх - Хялбар арга: ашиг, үнийн LIFO пункт нэмэх - Байнгын ба цаг үе систем - Дансны түлхүүр, тайлбар	Зарлагын Жиг дундаж, FIFO (венч) аргыг зөвшөөрч, харин LIFO (альт) аргыг хориглож болох юм
НББ ҮС-7	Мөнгөн гүйлгээний тайлан	- Зорилго, үйлчлэх хүрээ, нэр томъёо - Мөнгөн урсгал: Үндсэн, ХО, санхүү - Тайлагнал: шууд, шууд бус арга - ХО, санхүү МГ тайлан мөнгөн суурь - Валют, хүү, ногдол ашиг, татвар - Хамсаа, охин, хамтарсан компани дахь хөрөнгө оруулалт, худ. авалт - Тодруулга, <i>хавсралт I, II, III</i>	Жижиг мөнгөн сан, банкны тохируулгаар жишээ, бичилтийн загвар үйлдэж, тайлбарын хамт хавсралт III-т тусгах	Хэвээр
НББ ҮС-8	Тайлангийн цэвэр ашиг (алдагдал), суурь алдаа, бодлого өөрчлөлт	- Зорилго, үйлчлэх хүрээ, нэр томъёо - Цэвэр ашиг: хэвийн, онцлог зүйлс - Тооцооллын өөрчлөлт, залруулга - Суурь алдаа: венчмарк, байж болох - Бодлогын өөрчлөлт: венч, альт/хув - Тодруулга, тайлбар, хавсралт I, II, III	Хэвийн бус олз гарзын ангилал, тайлагналын загвар,схем	Хэвээр

НББ ҮС-10	Тайлангийн дараах үйл явц	- Зорилго, үйлчлэх хүрээ, нэр томъёо - Болзошгүй тохиолдол: олз, гарз - Балансын дараах үйл явц	Хэвээр	Хэвээр
НББ ҮС-11	Барилгын гэрээ	- Зорилго, үйлчлэх хүрээ, нэр томъёо - Гэрээт орлого: үнэ, нөхвөр, урамшил - Гэрээт зардал: үндсэн өртөг, хасалт - Орлого, зардал хүлээн зөвшөөрөлт: - Тодруулга, тайлбар, хавсралт I, II - Дансны загвар, аргачлал III, IV	Гүйцэтгэл хувь, гэрээ гүйцэтгэлийн дансны түлхүүр, журналын бичилт, тайлагналын загварыг бодит жишээгээр үзүүлэх (Хавсралт 3, 4)	Хэвээр
НББ ҮС-12	Орлогын татварын бүртгэл (SIC-21, SIC-25)	- Зорилго, үйлчлэх хүрээ, нэр томъёо - Татварын суурь: хөрөнгө, өр төлбөр - Тайлант, хойшлогдсон хөрөнгө, өглөг - Түр зөрүү: татвар ногдох, хасагдах - Ашиглаагүй татвар: алдагдал, зээл - Салбар, хараат, хамсаа, хамтар/ХО - Хэмжилт, хүл. зөвшөөрөх, тайлагнал - Тодруулга, хавсралт: зөрүү, үзүүлэн	Манайд НББОУС-12 өмнөх хувилбарыг Сангийн сайдын 1998 оны "Санхүү, татварын орлогын зөрүү зохицуулах журам"-д нийцүүлэн түр мөрдөж болох	Эсвэл НББОУС-12-ын шинэчилсэн хувилбарын танилцуулгын хэсэг - Манай нөхцөлд тохируулан шинэчлэх
НББ ҮС-14	Сегментийн тайлан	- Зорилго, үйлчлэх хүрээ, нэр томъёо - Сегмент: Бизнес, газар зүй, тайлагнах - Орлого, зардал, үр дүн, хөрөнгө, өглөг - Тайлагнах сегментүүдийг тогтоох - Сегментийн бүртгэлийн бодлогууд - Тайлагнал: анхдагч, хоёрдогч сегмент - Тодруулга, тайлбар, хавсралт I, II, III	Хэвээр	НББОУС-14 танилцуулга, зарим параграф манай нөхцөлд тохируулан өөрчилнө.
НББ ҮС-15	Үнийн өөрчлөлийн нөлөөг агуулсан мэдээлэл	- Зорилго, үйлчлэх хүрээ, тайлбар - Үнийн мэдрэмж, бүртгэх 3 арга (Ерөн-хий худалдан авах чадвар, шинэчилсэн өртөг, хосолсон) - Нэмэлт тайлбар ба тодруулга	Хэвээр	Хэвээр
НББ ҮС-16	Үндсэн хөрөнгө (SIC-14, SIC-23)	- Зорилго, үйлчлэх хүрээ, нэр томъёо - Хүл/зөвшөөрөлт, хэмжилт, ангилал - Үнэлгээ хэмжилт: Анхдагч (өртөг, сайжруулалт), дахин үнэлгээ - Элэгдэл: хугацаа, үлдэх өртөг, аргууд - Хянах ба нөхөх: хугацаа, арга, өртөг - Устгал, данснаас хасах, тодруулгууд	- Санхүү зорилгоор элэгдлийн 3 арга, татварын зорилгоор 5 арга гэж тодотгох - Дансны бичилтийн тайлбар	Ангилал-37 пунктыг өөрийн нөхцөлд тохируулж өөрчлөн шинэчлэх
НББ ҮС-17	Түрээс (SIC-15)	- Зорилго, үйлчлэх хүрээ, нэр томъёо - Ангилал, шалгуур, Тайлагнал-түрээс-лэгч: хөрөнгө, ҮА түрээс - Түрээслүүлэгч: хөрөнгө, ҮА түрээс - Борлуулалт, буцаалт - Тодруулга, тайлбар, хавсралт II, III	Хавсралт 2, 3 шинээр нэмж, Капитал түрээс, Лизингийн дансны бичилт, тайлагналын загвар, аргачлал нэмэх	Танилцуулгыг хасна.
НББ ҮС-18	Орлого	- Зорилго, үйлчлэх хүрээ, нэр томъёо - Орлогын хэмжилт, тодорхойлолт - ХЗ шалгуур: бараа, үйлчилгээ - ХЗ шалгуур: Хүү, лиценз, ногдол ашиг - Тайлбар: бараа, захиалга, хөрөнгө - Тодруулга тайлбар: Үйлчилгээ, бусад	Хэвээр	Хэвээр
НББ ҮС-19	Ажиллагчдын тэтгэвэр, тэтгэмж	- Зорилго, үйлчлэх хүрээ, нэр томъёо - Төрөл, сан, хөтөлбөр - АО шимтгэлийн сан: (Хүл. зөвш. тод) - Ажиллагчдын шимтгэлээр сан бүрдүүлэх: төрөл, хүлээн зөвшөөрөлт, - Хөтөлбөр дуусгах, тооцох, хасалтууд - Бүртгэх арга: Венч, альт хувилбар - Тодруулга тайлбар хавсралт	- Зохих пунктыг НДШ, Нэрийн данс, багц хуулиудыг үндэслэн манай нөхцөлд өөрчлөх - Монгол жишээгээр бичилтийн загвар бэлтгэх	НББОУС-19, НББОУС-26 гэсэн 2 стандартыг нэгтгэх ба энд гол нь монгол загвар гаргаж авах зорилт тавих нь чухал.
НББ ҮС-20	Улсын татаасын бүртгэл (SIC-10)	- Зорилго, үйлчлэх хүрээ, нэр томъёо - Хүлээн зөвшөөрөх, үл зөвшөөрөх - Бүртгэх арга: капитал, орлого - Тайлагнал: капитал, орлого - Буцаалт, тодруулга, шилжих нөхцөл	Хэвээр	Хэвээр

НББ ҮС-21	Валют ханш өөрчлөлт (SIC-7, SIC-11, SIC-19)	- Зорилго, үйлчлэх хүрээ, нэр томъёо - Хүл/зөвш-т: мөнч, альт, тайлагнал - Гадаад салбар: ангилал, тайлагнал борлуулалт, ангиллын өөрчлөлт - Татвар нөлөө, тодруулга, тайлбар	Данс, гүйлгээ, журналын бичилтийн загвар хийх	Хэвээр
НББ ҮС-22	Бизнес хамсрал ба нэгдэл (SIC-9, SIC-22)	- Зорилго, үйлчлэх хүрээ, нэр томъёо - Нэгтгэл: худалдан авах, хувь нэгтгэл - Худ/авах: бүртгэл, тайлагнал, өртөг, хөрөнгө, өр төлбөр: венч, альт/арга - Худ/авалт: хувьцаа, үнэ, гудвилл - Сөрөг гудвилл: венч, альт/арга - Х/авалт: залруулга ба өөрчлөлтүүд - Хувь нэгтгэл: бүртгэл, тайлагнал - Орлогын татвар, тодруулга, тайлбар	Худ/авалт, хувь нэгтгэл аргаарх бизнес хамсралын журналын бичилт, тайлагналын загварыг бодит жишээгээр аргачлалын хамт үзүүлэх	Хэвээр
НББ ҮС-23	Зээл ашиглалтын зардал (SIC-2)	- Зорилго, үйлчлэх хүрээ, нэр томъёо - Хүл/зөвшөөрөлт: мөнч, альт/арга - Капиталжуулалт: эхлэх, түдгэлзэх - Тодруулга, шилжилт, тайлбар	Зээлийн хүүг капиталжуулах тооцоолол, дансны бичилтийн загвар хавсаргах	Хэвээр
НББ ҮС-24	Холбоотой талын тодруулга	- Зорилго, үйлчлэх хүрээ, нэр томъёо - Холбоотой талын тухай - Тодруулга	Хэвээр	Хэвээр
НББ ҮС-27	Нэгдсэн тайлан, охин компанийн хөрөнгө оруулалтын бүртгэл (SIC-12)	- Зорилго, үйлчлэх хүрээ, нэр томъёо - Нэгдсэн тайлангийн шаардлага - Нэгдсэн тайлангийн хамрах хүрээ - Нэгдсэн тайлангийн аргачлал - Төвд салбарт оруулсан ХО тусгах - Тодруулга - Дансны түлхүүр, бичилт, тайлагналын загвар (хавсралт)	Төв, салбарын бүртгэл, дансны бичилт, тохируулга, нэгтгэлээр загвар бэлтгэж, аргачлалын хамт хавсаргах	Хэвээр
НББ ҮС-28	Хамсаа компанийн хөрөнгө оруулалт (SIC-3, SIC-20)	- Зорилго үйлчлэх хүрээ, нэр томъёо - Нөлөөлөл, капитал ба өртгийн арга - Бүртгэл: капитал арга, нэгтгэл - Капитал аргын хэрэглээ - Тодруулга, Хавс-т дансны загвар	- Капитал аргын бичилтийн загвар - Капиталаас өртөгт шилжих бичилт, залруулга	Хэвээр
НББ ҮС-29	Ханш хэт уналтын үеийн санхүүгийн тайлан (SIC-19)	- Зорилго, үйлчлэх хүрээ, нэр томъёо - СТ хөрвүүлэх: суурь үнэ, тэнцэл - Орлогын тайлан, мөнгөн ашиг/алд - Тэр үе ханш: баланс, орлого, мөнгөн ашиг, мөнгөн гүйлгээ, нэгдсэн тайлан - Индекс сонголт, тодруулга, тайлбар	Санхүүгийн тайлан хөрвүүлэлтийг бодит жишээгээр загварчлан үзүүлэх	Хэвээр
НББ ҮС-30	Банк, адилтгах байгууллагын санхүүгийн тайлангийн тодруулга	- Зорилго, үйлчлэх хүрээ, нөхцөл - Бүртгэл/бодлого, орлогын тайлан - Баланс, болзошгүй тохиолдол, өр - Хөрөнгө өглөг төлөгдөх хугацаа - Актив пассив төвлөрөл, бал/гад/үз - Зээл, урьдчилгааны алдагдал - Эрсдэл, барьцаа, итгэмжлэл, хол/тал	Хэвээр	Хэвээр
НББ ҮС-31	Хамтарсан үйлдвэрийн хувь оролцоог санхүүгийн тайланд тусгах (SIC-13)	- Зорилго, үйлчлэх хүрээ, нэр томъёо - Хэлбэр, гэрээ контракт - Хамтын хяналт: үйл ажиллагаа - Хамтын хяналтын хөрөнгө - Хамтын хяналтын үйлдвэрүүд - Баталгаажуулсан санхүү тайлан, - Санхүүгийн тусгайлсан тайлан - Хувийг тусгах, тодруулга, хавсралт	Дансны бичилт, тайлагналын загвар хавсралтаар үзүүлэх	Хэвээр
НББ ҮС-32	Санхүүгийн хэрэглүүр (хэмжих, зөвшөөрөх, тайлагнах, тодруулах)	- Зорилго, үйлчлэх хүрээ, нэр томъёо - Хүл.зөвш-т: өр төлбөр, капитал - Ангилал: өр, өмч, хүү, ногдол ашиг - Хөрөнгө, өр төлбөрийн тэнцвэр - Хэмжилт: анхны, дараах, венч/арга - Урт хугацаанд ашиглах ба дуусгах - Хамгаалалт: тодотгол, хүл/зөвш, дуусах	Хэвээр	Хэвээр
НББ ҮС-33	Нэгж хугацаанд ногдох ашиг	- Зорилго, үйлчлэх хүрээ, нэр томъёо - Хэмжилт: суурь ашиг, Ашиг-суурь	Хэвээр	Хэвээр

	(SIC-24)	- Хэмжилт: нэгж хувьцаа-суурь - Хорогдуулсан ашиг - Хөрвөх чадвартай хувьцаа - Хорогдуул/чадамж энгийн хувьцаа - Тайлагнал, тодруулга	Хэвээр	Хэвээр
НББ ҮС-34	Завсрын санхүүгийн тайлан	- Зорилго, үйлчлэх хүрээ, нэр томъёо - Бүрдэл ба хэлбэр - Тайлбар бичиг ба тодруулга - Хугацаа, материаллаг байдал - Хүлээн зөвшөөрөлт, хэмжилт - Дахин тайлагнал, Хавсралт I, II, III	Хэвээр	Хэвээр
НББ ҮС-35	Зогсоох үйл ажиллагаа	- Зорилго, үйлчлэх хүрээ, нэр томъёо - Үнэлгээ, хэмжилт загвар - Хүлээн зөвшөөрөлт, хөрвүүлэлт - Тайлагнал, тодруулга	Хэвээр	Хэвээр
НББ ҮС-36	Хөрөнгийн бууралт	- Зорилго, үйлчлэх хүрээ, нэр томъёо - Үнэлгээ, хэмжилт загвар - Хүлээн зөвшөөрөлт, хөрвүүлэлт - Тайлагнал, тодруулга	Хэвээр	Хэвээр
НББ ҮС-37	Нөөц, болзошгүй өр төлбөр, хөрөнгө	- Зорилго, үйлчлэх хүрээ, нэр томъёо - Нөөц: баталгаа нөхвөр, амралт цалин, урс/засвар, резин дугуй, бусад - Болзошгүй: магадлал, шүүх зарга, баталгаа, нөхвөр, байгаль орчин г.м. - Болзошгүй ашиг ба алдагдал - Тайлагнал, тодруулга	Хэвээр	Хэвээр
НББ ҮС-38	Биет бус хөрөнгө	- Зорилго, үйлчлэх хүрээ, нэр томъёо - Төрөл/12-20 п/, хүлээн зөвш-т, өгөөж - Олж бэлтгэх өртөг: тусгай, бизнес хамсрал, дотоод гудвилл /27-43 п/ - Анхны хэмжлт: тусгай, хамсрал, дотоод, татаас, солилцоо, дагавар зард. - Эхний ХЗ хэмжилт: менч, альт/арга - Элэгдэл: хугацаа, арга, үлдэх өртөг - Хянах: үе, арга, нөхөлт: менч, альт - Хасалт, тодруулга. Хавсралт	Зарим нэр, хугацааг Монголын патент, Зохиогч эрхийн Хуульд нийцүүлэх - Патент, гудвил-аар бодит жишээ, дансны бичилт загвар хавсаргах	ННБОУС-38 ба E-50 төслийг жишиж, өөрчлөлтийг нэгбүрчлэн авч үзэх
НББ ҮС-40	Хөрөнгө оруулалтын бүртгэл	- Зорилго, үйлчлэх хүрээ, нэр томъёо - Ангилал, өртөг, үнэлгээ, дахин үнэлэх - Бүртгэл: өмчлөл, хасагдуулга, хасах - Тайлагнал, төрөлжсөн газар, татвар - Тодруулга, тайлбар хавсралт	Өмчийн аргын журналын бичилтийн загвар хийж хавсаргах	Хэвээр
НББ ҮС-41	Хөдөө аж ахуй	- Зорилго, үйлчлэх хүрээ, нэр томъёо - Ангилал, өртөг, үнэлгээ, дахин үнэлэх - Бүртгэл: өмчлөл, хасагдуулга, хасах - Тайлагнал, төрөлжсөн газар, татвар - Тодруулга: тайлбар хавсралт	- Өмчийн аргын журналын бичилтийн загвар хийж хавсаргах	Хэвээр

Бизнес орчны стандартын төсөл нь тунхаглал, удиртгал хэсгээс гадна санхүүгийн тайлагнал, өмч хөрөнгө, үүрэг хариуцлага, санхүүгийн үр дүнгийн гэсэн 3 бүлэг 32 стандартыг хамарч байна.

Бизнес орчны бүртгэлийн төсөл (НББС-0) Бидний толилуулан хэлэлцүүлж буй "Санхүүгийн тайланг бэлтгэх, мэдээлэх үндсэн зарчим" төслийн баримт бичигт Монгол дахь бүртгэлийн, шинэчлэлийн үзэл баримтлал, мэдээллийн даяарчлалд нэгдэх концепци, олон улсын бүртгэлийн стандартад нийцсэн аккрузл суурьт нягтлан бодох бүртгэлийн томъёолол ба хэрэглээ, үндэсний хэв загвар бүхэлдээ тусгагдсан.¹

Энэ баримт бичигт гадаад санхүүгийн тайлагналын цар хүрээ, нийтлэг зорилготой тайлангийн зорилго, баримтлах зарчим, нийтээр зөвшөөрсөн таамаглал, санхүүгийн элементүүдийн тодорхойлолт, үндсэн шинжүүд ба хүлээн зөвшөөрөх шалгуур, үнэлгээ хэмжилтийн үндэс, нийтээр зөвшөөрсөн венчмарк болон, альтернатив хувилбаруудын сонголт, аккрузл суурийн хэрэглээнд холбогдох нягтлан бодох бүртгэлийн ерөнхий ба тусгай бодлого горимуудыг дэвшүүлэн тавьсан.

Тунхаглал бэлтгэхдээ "Санхүүгийн тайланг бэлтгэж танилцуулах зарчим" НББОУСХ-ны үндсэн баримт бичиг,² АНУ-ын Нягтлан Бодох Бүртгэлийн Зарчмын Хорооны (APB) тайлан №4³, тэрчлэн бизнес, ашгийн бус байгууллагын тайлагналд холбогдох АНУ-ын Санхүүгийн Бүртгэлийн Стандартын Хорооноос (EASB) 1978-1985 онд гаргасан "Санхүүгийн Бүртгэлийн Ухагдахууны Тунхаглал" баримт бичгүүдийг ашиглав.*

Санхүүгийн тайлагналын стандартуудын (НББҮС-1, НББҮС-7, НББҮС-10, НББҮС-14, НББҮС-15, НББҮС-22, НББҮС-24, НББҮС-27, НББҮС-29, НББҮС-30, НББҮС-32, НББҮС-34) төсөлд нягтлан бодох бүртгэлийн бодлого горим, санхүүгийн тайлагналын цар хүрээ, тодруулга, сегмент ба завсрын тайлагнал, бизнес хамсрал, санхүүгийн тайлангийн нэгтгэл ба цөөнхийн ашиг сонирхлын тайлагнал, мөнгөн гүйлгээний тайлан, санхүүгийн хэрэглүүрүүд ба ханш хэт уналтын үеийн санхүүгийн тайлангийн тулгамдсан асуудлууд хөндөгдсөн.

Өмч, хөрөнгө, үүрэг хариуцлагын стандартуудад (НББҮС-2, НББҮС-16, НББҮС-17, НББҮС-19, НББҮС-20, НББҮС-28, НББҮС-31, НББҮС-37, НББҮС-38, НББҮС-40, НББҮС-41) бараа материал, биет, биет бус хөрөнгө, түрээс, хөрөнгө оруулалтын гүйлгээ, ажиллагчдын тэтгэвэр, тэтгэмжийн хөтөлбөр, нэрийн дансны бичилтүүд, улсын татаас, хамтарсан үйлдвэрийн хувь оролцоо, баталгаа, нөхвөр, өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт, үнэлгээ ба хэмжилтүүд, бүртгэл, хяналт, удирдлагын асуудлууд тусгагдсан.

Санхүүгийн үр дүнгийн стандартуудын (НББҮС-8, НББҮС-11, НББҮС-12, НББҮС-18, НББҮС-21, НББҮС-23, НББҮС-33, НББҮС-35, НББҮС-36, НББҮС-39) төсөлд аккрузл суурийн дагуу орлого, зардал хүлээн зөвшөөрч, санхүүгийн үр дүнг хэмжих үндсэн нөхцлүүд ба орлогын татварын бүртгэл хяналтын асуудлууд гол байрыг эзлэж байна. Монгол бүртгэлийн үндэсний стандартын төсөл бэлтгэх ажилд мэргэжлийн 60 гаруй багш, судлаачид оролцсон ажлын 16 баг ажиллаж байна.

Стандарт бүрт зорилго, үйлчлэх хүрээ, нэр томъёоны тайлбар, төрөл ба объект, хүлээн зөвшөөрөлт, үнэлгээ, хэмжилт, бүртгэл хяналтын үндсэн ба байж болох хувилбаруудын сонголт, тайлагнах арга ба тодруулгуудыг эх стандартын дагуу тусгасны дээр салбар, бүс нутаг, үндэсний онцлог, дансны бичилт, тайлагналын хэв загваруудыг тайлбар хавсралтуудаар үзүүлэх юм.

¹ Баримт бичгийн төслийг зохиогчоос өргөн барьсныг мэргэжлийн байгууллага дэмжин, "Санхүүгийн мэдээ" сонины 2001 оны №22, 23, 24-д хэвлэн нийтээр хэлэлцүүлж буй.

² International Accounting Standards 2001, IASC, 47-84 тал

³ Нягтлан бодох бүртгэлийн зарчмын хорооны тайлан №4. "Бизнес байгууллагын санхүүгийн тайлангийн үндсэн ухагдахуун ба нягтлан бодох бүртгэлийн зарчмууд", Нью-Йорк: Америкийн мэргэшсэн нягтлан бодогчдын институт, 1970 он

* Тунхаглал дараах 6 баримт бичгээс бүрдэнэ 1. СБСТ №1. "Бизнес байгууллагын санхүүгийн тайлангийн зорилтууд", Стамфорд, Конн: СБСХ, 1978 оны 11сар. 2. СБСТ №2. "Нягтлан бодох бүртгэлийн мэдээллийн чанарын шинж чанарууд", Стамфорд, Конн: СБСХ, 1980 оны 5 сар. 3. СБСТ №3 "Бизнес байгууллагын санхүүгийн тайлангийн элементүүд" Стамфорд, Конн: СБСХ, 1980 оны 10 сар. 4. СБСТ №4 "Бизнесийн бус байгууллагын санхүүгийн тайлагналын зорилтууд" Стамфорд, Конн: СБСХ, 1980 оны 12 сар. 5. СБСТ №5. "Бизнес байгууллагын санхүүгийн тайлан дахь хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт" Стамфорд, Конн: СБСХ, 1984 оны 12 сар. 6. СБСТ №6 "Санхүүгийн тайлангийн элементүүд" Стамфорд, Конн: СБСХ, 1985 оны 12 сар.